



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН  
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ  
**СУРГАЛТ, СУДАЛГААНЫ  
ХҮРЭЭЛЭН**

Сургалт, судалгааны хүрээлэнгийн байр,  
Чин ван Чагдаржавын гудамж, 1 дүгээр хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 7014 3344, Цахим шуудан: gpo\_tri@prosecutor.mn,  
Цахим хуудас: www.prosecutor.mn

2024.05.08 № 1/1  
таний -ны № -т

Г Илтгэлийн уралдааны тухай

Тус хүрээлэн нь Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтэс, Монголын Хуульчдын холбоотой хамтран “Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад прокурорын оролцоо” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зохион байгуулж байна.

Энэхүү арга хэмжээ нь их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх сонирхол, санаачилгыг дэмжих, илтгэх ур чадвар, арга барилыг төлөвшүүлэх, төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад прокурорын оролцох оролцооны талаар нийтэд мэдээлэн хүргэх зорилготой юм.

Иймд эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд оюутан, суралцагчдыг оролцуулж, хамтран ажиллахыг хүсье.

Удирдамжийг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ  
ПРОКУРОР, СУРГАЛТ, СУДАЛГААНЫ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D)

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ, ДОКТОР, ПРОФЕССОР  
Б.АМАРСАНАА ТАНАА



0000000002



## “ТӨР, НИЙТИЙН АШИГ, СОНИРХЛЫГ ХАМГААЛАХАД ПРОКУРОРЫН ОРОЛЦОО” СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2024 оны 05 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

### Нэг. Зорилго

Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх сонирхол, санал, санаачилгыг дэмжих, илтгэх ур чадвар, арга барилыг төлөвшүүлэх, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад прокурорын оролцох оролцооны талаар нийтэд мэдээлэн хүргэхэд оршино.

### Хоёр. Зохион байгуулагч

-Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтэс;  
-Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн;  
-Монголын Хуульчдын холбооны Прокурорын холбоо;  
-Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо.

### Гурав. Илтгэлийн үндсэн чиглэл

1. Төр, нийтийн ашиг сонирхлын ойлголт, эрх зүйн зохицуулалт, гадаад улсын сайн туршлага, харьцуулсан судалгаа;
2. Монгол Улсын хууль тогтоомжид төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад прокурорын оролцох оролцоог тодорхойлсон түүхэн уламжлал, одоогийн эрх зүйн зохицуулалт, боловсронгуй болгох арга зам;
3. Хүрээлэн буй орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд прокурор нэхэмжлэл гаргах нь;
4. Нийтийн өмчийг хамгаалахад прокурорын оролцоо;
5. Засгийн газрын тусгай сангудад учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд прокурорын оролцоо;
6. Эрүүл мэндийн даатгалын санд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд прокурорын оролцоо;
7. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, ажлаас халсны улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд прокурорын оролцоо;
8. Гэмт хэргийн улмаас төр, нийтэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх прокурорын нэхэмжлэл, шийдвэрлэлт;

- Прокурор, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалан иргэн, захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй эрх зүйн зохицуулалтыг гадаад орны хууль тогтоомжтой харьцуулах нь.

#### **Дөрөв. Илтгэлийн шалгаруулалт**

1. Уралдааныг их, дээд сургуулиудын оюутнуудын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 24, 30-ны өдрүүдэд хоёр үе шаттай зохион байгуулна.

2. Илтгэлийг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр [bbatmagnai1010@gmail.com](mailto:bbatmagnai1010@gmail.com) хаягаар хүлээж авна.

3. Эхний шатанд ирсэн илтгэлүүдтэй зохион байгуулагчид танилцаж, шаардлага хангасан илтгэлүүдийг эмхэтгэлд оруулахаар шалгаруулна.

4. Эмхэтгэлд оруулахаар сонгогдсон илтгэлүүдээс 8 илтгэлийг сонгон шалгаруулж 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн танхимд хэлэлцүүлэх ба илтгэл ирүүлсэн оюутнуудыг тус хэлэлцүүлэгт урилгаар оролцуулна.

5. Илтгэл хэлэлцүүлэх үед илтгэгчийн илтгэх үндсэн хугацаа 15 минут, асуулт, хариултын хугацаа 5 минут байна.

#### **Тав. Илтгэлд тавигдах шаардлага**

- Зарласан сэдвийн хүрээнд илтгэлийн сэдвийг сонгосон байх;
- Сонгосон сэдвийн хүрээнд бодит нөхцөл байдал, дэвшүүлж буй шийдлийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх;
- Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдсан, шинэлэг санаа дэвшүүлсэн байх;
- Илтгэл нь хураангуй, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, иш татсан ном зохиол, бүтээл, судалгаа, эх сурвалжийг тодорхой дурдсан байх;
- Илтгэлийн зохиогч нь нэг буюу хоёр этгээд байж болох ба зохиогчийн нэрийг илтгэлийн эхний нүүрэнд бичсэн байна. Илтгэлийг багшийн удирдлага дор бичиж болно.
- Илтгэл нь зохиогчийн эрхийг зөрчөөгүй байх;
- Илтгэл нь А4 цаасан дээр 5-10 нүүрэнд багтсан, мөр хоорондын зай 1.15, үсгийн хэмжээ 12; Arial фонтоор /MS Word/ бичигдсэн байх ба зохиогчийн CV буюу товч намтрыг хавсаргасан байна;
- Илтгэл өмнө нь мэргэжлийн сэтгүүл, ном, хэвлэл, цахим орчинд нийтлэгдээгүй байна.

#### **Зургаа. Шагналын сан**

- |             |   |
|-------------|---|
| I байр      | -Өргөмжлөл, 500 000 / таван зуун мянган төгрөг /  |
| II байр     | -Өргөмжлөл, 400 000 / дөрвөн зуун мянган төгрөг / |
| III байр    | -Өргөмжлөл, 300 000 / гурван зуун мянган төгрөг / |
| Тусгай байр | -Өргөмжлөл, 100 000 / нэг зуун мянган төгрөг /    |

Илтгэл хэлэлцүүлсэн оюутнуудад өргөмжлөл гардуулна.

Холбогдох мэдээлэл авах утас, хаяг:

Монголын Хуульчдын холбооны

Прокурорын хорооны мэргэжилтэн Б.Батмагнай

Холбогдох утас: 8686 3375

E-mail: [bbatmagnai1010@gmail.com](mailto:bbatmagnai1010@gmail.com)